



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/08

Булган сум

“Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал  
жуулчлалыг дэмжих” арга хэмжээний  
зардлын хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлуулах тухай” XIII/02 тогтоол, 2022 оны XII Хуралдааны XII/21 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих” төсөл арга хэмжээний зардлын 120,000,000 (нэг зуун хорин сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т тус тус үүрэг болгосугай.

3.Батлагдсан төсөл, арга хэмжээний зардлыг хууль журмын дагуу санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны  
01. дүгээр сарын 12-ны өдрийн А/08 дугаар  
захирамжийн хавсралт



Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих  
арга хэмжээний зардал

Д/д	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мянган төгрөг)	Хүрэх үр дүн
1	2	3	4
1	"Visit Bulgan 2023" аялал жуулчлалын форум зохион байгуулах	9,500.0	Төр, хувийн хэвшлийн хооронд хамтын ажиллагааны хүрээнд Аялал жуулчлалын салбар дахь дотоод, гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэн, орчны бохирдолгүй, эрүүл аюулгүй үйлчилгээтэй "Эко аялал жуулчлалын загвар аймаг" болно.
2	Эвент арга хэмжээнд зориулалтын зөөврийн био жорлон худалдаж авах (өвөл, зуны тус бүр 5 ш)	65,000.0	Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд шаардлагатай.
3	Нутгийн иргэдийн оролцоог дэмжих бүсчилсэн сургалт зохион байгуулах	15,000.0	Булган аймгийг зорин ирэх аялагч жуулчдыг татаж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжинө.
4	Орон нутгийн онцлог брэнд хоол үйлчилгээг бий болгох	5,000.0	Залуу тогооч нарын улсын уралдаанд аймгийн брэнд хоол тодруулан гаргаж ирнэ.
5	Эвент арга хэмжээнд зориулсан Монгол соёл, ахуйг сурталчилсан сийлбэртэй гэр худалдан авах	18,500.0	Булган аймгийн аялал жуулчлалыг олон нийтэд сурталчилна.
6	Эко аялал жуулчлалын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	7000.0	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад аймгийнхаа аялал жуулчлалын бүс нутагт дадлага сургуулилт хийх боломж бололцоог бүрдүүлнэ.
Нийт дүн		120,000.0	